



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 100

Номгон

**Тээврийн хэрэгсэл, түлшний мод  
балансаас балансад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, “в”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 1.3, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Заг сумын Эрүүл мэндийн төвийн хөрөнгөд бүртгэлтэй 2014 онд ашиглалтад орсон УАЗ-315195 маркийн 18-66БНХ улсын дугаартай автомашиныг тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, Баянхонгор сумын нэгдүгээр Цэцэрлэгийн эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 2 800 000 төгрөгийн өртөг бүхий түлшний модыг Цэвэр хот ХХК-д үнэ төлбөргүй балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.


2.1. Тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор түлшний модыг тоолж балансаас балансад шилжүүлэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Шилжүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 11 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190161